

анархизмийг төрүүлдэг гол замын нэг юм.

Зургаад, хүний эрхийн ардчилал бас засаглалыг сулруул хууль, ёс суртахууныг доройтуулдаг давхар нөлөөтэй тооцон хачадсангүй. Эртний уламжлалтай ёс суртахууны үнэт зүйл устгалта болж, хар амиа хичээх, зоосны нүхээр бүхнийг харах, хуурмэхлэх, авилгалд идэгдэх, эрхээ шаардаж цээжээ дэлдэх явдгаарсан нь нийгмийн харилцааг хэвтрэгшүүлж, эх орноо хайрлах тусгаар тогтнолоо эрхэмлэн дээдлэх, үндэстэнийхээ эрх ашгийг мэдэрэх зэрэг хүмүүсийн мэдрэмж, оюун санааны үнэт зүйлсийг алхам алхмаар үгүй хийх боллоо. Энд төрийн хатуу бодлого, хүмүүжлийн хатуу боловсрол байх ёстойг төр өөрөө төдийгүй төрийг бүрдүүлэгч хүмүүс хараа хяналтаасаа алдаж явцуурчээ.

Долоод, ардчиллын зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг болс чөлөөт хэвлэл манайд зүй ёсоороо бүрэлдэн тогтож чадсангүй. Харин бидний дунд ёс суртахууны болон оюун санааны аливаа ариун үнэт зүйлсээс антид хамгийн ухамсаргүй хэвлэл бүрэлдэ тогтож, доромжлол, гүтгэлэг, гүжирдэл, бухимдалт, хов жи аймшиг, цочирдуулалт, хиймэл дуулианаар нийгмийг үерлүүл, өөрсдийнхөө гарт дөрөвдөгч засаглал байна хэмээн орицлоо буй нь үнэн хэрэг дээрээ бүх нийтийн хардлага сэрдэл, үл итгэлцэл хувь хүнийг үнэ цэнээ алдаж зөвхөн нийгмийн амьтан төдийд үзэ сэтгэхэд үйлчилж байна. Иймд хүний ухамсрын жолоодлого бүх өөрөө өөрийгөө удирдах ёс голлодог ардчилсан чөлөөт байдла Монгол хүний зан чанарын сайн талыг сулруулж, нэн муу тал бүх долодог ур долигдуур, атаач жетөөч, матаач ухаач, бие биеэ хэмлэ эвдрэлцдэг занг дэвэргэж болзошгүйг урьдчилан харж чадсангүй. Энэ бол үндэстэн өөрийнхөө дүр төрхийг алдаж устаж үгүй болохо хүргэх ууд хаалга гарцаагүй мөн.

Наймд, өрнөдийн маягийн хүний эрхийн тухай ойлголты нийгэмд хэт түгээх нь зөвхөн эрхээ эхэлж ухамсарлах талаа хөгжсөн сэтгэхүйтэй ард түмэнд буруугаар нөлөөлж, өөрийнхө муу сайн аяг зан бүрийг хүний эрх хэмээн ойлгож, цээжээ дэлдэ дураараа дургиж, засаглал, хууль өөдөө нүлмидэг нөхцөл бүрдэ боломж тавьж өгдөггүйг урьдаас ойлгосонгүй. Энэ бол төрий удирдлагагүй анархи байдлыг үүсгэх гол зам мөн.

Энэ бүхэн Монголын ардчиллыг аргагүй л доошоо гулгахад хүргэж нийгэмд анархи харилцаа, анархи сэтгэлгээ голлохо.

сүргээ. Шилжилтийн үеийн онцгой байдлын улмаас төр энэ байдал дээр хяналтаа бүрэн алджээ. Гэтэл төр болж өгвөл ямар ч төр өөрийнхөө функцийг гүйцэтгэж байх ёстой. Хэрвээ хяналтаа алдсан бол маш түргэн сэргээн тогтоох чадвартай байх ёстой.

Эдүгээ Монголд ардчиллын шилжилтийн үе өнгөрч байна. Эхдээ төр хяналт, зохицуулалтынхаа апаратыг сэргээн ангалтаагүй бол энэ үе Монгол орны хувьд хязгааргүй үргэлжилж матадгүй юм. Монголд дутагдаж буй цорын ганц зүйл бол төр мөн. Монголд илүүдэж буй цорын ганц зүйл бол анархи мөн. Тиймээс Монгол хүний хувьд төр минь сэргээч, бүхнийг эвэлл дороо авч Монголын төрийн уламжлалын дагуу "иргэний амь төрдөө, төрийн амь иргэндээ" гэдэг ёсыг сэргээгээч хэмээн мөргөнөм.

Төрийн сулд өршөөг!

**ГАДААД БОДЛОГО, ДИПЛОМАТ АЖИЛЛАГААНЫ
ЗАЛГАМЖ, НЭГДМЭЛ ЧАНАРЫН ТУХАЙ
ӨГҮҮЛЭХ НЬ***

**МУИС, ОУХС-ийн профессор,
доктор (Ph.D) Д.Цолмон**

Аливаа улсын гадаад бодлого, дипломат үйл ажиллагаа хоёр нэгт холбоотой бөгөөд гадаад бодлого нь харьцангуй тогтвортой, хүн ардаа энх тунх, элбэг хангалуун аж төрөх, дэлхийн улс түрнүүдийн дотор зохих байр сууриа эзлэж үндэсний эрх ашгаа дээдлэх чиглэлтэй байдаг билээ. Ухаантай, эх оронч үзэлтэй төрийн томоохон зүтгэлтэн, улс төрийн бодлогыг боловсруулагчид мөнхөд орших үндэсний ашиг сонирхлыг эрхэмлэн дээдэлж тэр нь хожмын үйлсийн мөнхийн жигүүр болсон авай. АНУ-ын нэрт улс төрч, соён гэгээрүүлэгч Бенжамин Франклин, Томас Жефферсон нар болон сонгодог дипломат уламжлалтай Английн торд Пальмерстон, ерөнхий сайд Черчилль, Францын ерөнхийлөгч Де Голль нарын гадаад бодлогын талаар хэлсэн үг, бүтээлүүдэд ийм санаа нь нэвт шингэсэн байдаг.

*Эл өгүүлэл "Өнөөдөр" сонины 2000 оны 10-р сарын 27-ны дугаарт хэвлэгдсэн.

Аль нь тодорхойлох вэ?

Улс орны дотоод амьдрал, эдийн засгийн хөгжил, соёлын байдал, боловсрол, улс төр нийгмийн харилцаа гадаад бодлогод хүчтэй нөлөөлөх тул дотоод дахь эдийн засаг, нийгмийн асуудлыг чадвартай эмхэлсэн, боловсронгуй хуультай, эдийн засгийн чадавчтай улс орнуудын олон улсын нэр хүнд өндөр байдаг юм. Өөрөөр хэлбэл гадаад бодлого, гадаад үйл ажиллагаа нь дотоод бодлогоос урган гардаг гэсэн үг юм. Тэгэхдээ энэ хоёрын аль нэг нь нөгөөгөө нөхөж харилцан үйлчилдэг ухагдахуун мөн.

Аль нэг улс орны өнгөрсөн, эдүгээг жишин үзвээс эдийн засгийн чадавхи султай, батлан хамгаалах чадвар сул, буура хөгжилтэй, хүн ард нь эрх баригчид, засаг төрдөө итгэл алдарса байгааас эсвэл дипломатууд нь суурь боловсролгүй, эх орон үзэлгүй болвоос идэвхитэй ухаалаг гадаад бодлого хэрэгжүүлэх нэн төвөгтэй болно.

Цагаан морин жилээс хойш бид нэг орноос хэт хараа байдлаас ангижирч үзэл сурталжисан, үндэсний эрх ашгаа умартсан гадаад харилцаанаас ангижирахад томоохон алхам хийсэн. Хуучин социалист системд багтаж байсан орнууд нийтэ эдийн засгийн нийтлэг бэрхшээлүүдтэй тулгарч байсан авч алсы хараатай, өөрийн гэсэн үндэсний бодлоготой улс орнууд хуучин тогтолцооноос үүдэлтэй бэрхшээлүүдийг харьцангуй богинохо хугацаанд давж гарсаар байна. Манай засаг төр, түүний түшээдий гадаад үйл ажиллагаанд авууштай сайн зүйл, хаявал зохи харалган үйл явдлын алийг нь өгүүлж барах вэ? Үүнээс зарим нэ зүйлийг нь дурдсу. 1993 онд манай улсын ерөнхийлөгч ОХУ- албан ёсны айлчлал хийх үеэр хоёр орны харилцааны хамгий эгзэгтэй асуудалд сайн бэлтгэлгүй хүний ам хардаг зангаара хандсан гэж хэлэхэд хилсдэхгүй. Үүний нэг нь 1930-40-өөд он Монголд болсон хэлмэгдүүлэлтийг ЗХУ, Коминтерн, зөвлөлтий сургагч нар дэглэн оролцож байсныг хүлээн зөвшөөрсөн атла "Үүний хариуцлага өнөөгийн Орос улсад холбогдолгүй юм" гэ дүгнэжээ. Энэ хэлмэгдүүлэлтийг өнөөгийн Орос улс хийгээгүй н үнэн. Гэтэл яг энэ үеэр яригдсан ЗХУ-ын үед хуримтлагдсан өрий асуудлыг ОХУ өвлөн авч байгаа манайх зөвшөөрсөн ба айлчлал сайн бэлтгэлгүй аман дээрээ алгадүүлж байсныг санаж байна.

Д.Долмон

"Гадаад бодлого, дипломат ажиллагааны загнамж, нэгдмэл чанарын тухай өгүүлэх нь"

1993 онд ОХУ-аас Монголд сууж байсан Элчин Сайд Разов ЭСЯ-даа хэвлэлийн бага хурал хийлгээд "...өрийн асуудлаар ЭСЯ-д багтсан бичгийг айлчлалаас дөрөвхөн хоногийн өмнө Оросын талд хэлмэгдүүлэлтийг би биш танай ГХЯ, Москва дахь танай ЭСЯ-ны үзвээрэй. Мөнөөх Разов айлчлалын өмнө "...Миний ойглож байгаагаар хоёр орны ард түмний сэтгэлийг гүнээ эмзэглүүлсэн ноцтой асуудал өнөөдөр байхгүй..." гэж байв.

Тиймээ, тэдний сэтгэлийг эмзэглүүлсэн асуудал байгаагүй, хэлмэгдүүлэлтийн хариуцлагыг тэд үүрэхгүй ч, өрийн асуудлыг ашигтай шийдвэрлүүлэх амлалтыг монголын албаны хүмүүсээс авч чаджээ. Энэ бол Оросын дипломат ажиллагааны амжилт гэхээс хахав. Тэр бүхнийг Ерөнхийлөгч бус гадаад харилцааг удирдан алба хашиж байсан эрхэмүүд хариуцах ёстой байсан юм. Польш, Унгарын тал хэлмэгдсэн хүний амь нас, цэргийг нь нутагтаа байрлуулсны хөлс гээд томоохон хэзэр гаргаж Оростой тоглосон шүү дээ. Өрийг монголчууд өөрсдөө тооцож үзсэн үү, уул овоо шиг алт мөнгө, хямд түүхий эдээ ямарч тооцоолгүй хүний гарт даатгаад түүгээр ч барахгүй газар нутгаасаа таслан өгч, хил хязгаараа нээлттэй орхиж байсны уршгийг бид бишгүй л амсгаа.

Эх орныхоо төлөө дуугарч амь амьдралаараа дэнчин тавьсан С.Аварзэд (Ерөнхий Сайдын орлогч, Гадаад Яамны сайд агсан) Туватай залгасан түүхэн хилийг өөрчлөхгүй, газар нутгаасаа хууль зохийн ямар ч үндэслэлгүйгээр ЗХУ-д таслан өгөхгүй гэж зүтгэсээр амь амьдралаараа дэнчин тавьж насан туршдаа хавчигдсаар дипломатч, шударга, чадалтай, халуун эх оронч хүн байсныг мартаж учиргүй. Эдүгээ ОХУ-ын Туватай хиллэдэг хоёр аймгийн ард иргэд эх нутгаа орхин, төв суурин бараадад дүрвэж баян хязгаар нутаг эзгүйрсээр байна. Давстын нэгэн сэхээтэн ерээд оны сүүлчээр хилийн цаана орших төрж өссөн өвөлжөө бууц, тоглож байсан нутгаа харан санаа алдаж, нүдэндээ нулимстай яваагаа харуусан бичсэн байв. Энэ бол зүгээр л нэг малын хулгайн хэрэг гараад байгаа юм гэвэл дэндүү гэнэн ойглолт болно. Тэгэхээр харалган, үндэсний эрх ашгаа умартсан гадаад бодлого ямар асуудал хүргэдгийн амьд жишээ энэ мөн.

Монгол Оросын харилцааны сүүлийн үеийн зарим баримт

Д.Долмон

"Гадаад бодлого, дипломат ажиллагааны загнамж, нэгдмэл чанарын тухай өгүүлэх нь"

сөхье. Оросын талтай визетэй зорчих саналыг Ерөнхийлөгчүүдүүдийнхээ нүдийг нээе гэсэн бодол хүнд байдаг л байх л даа. гаргаагүй. Үүнээс бидний монголчууд хожиж байна уу? Үгүй л ба Мэргэжлийн үүднээс үзвэл Монгол улсын гадаад бодлого, шуу. Улс орон дотоод амьдрал, гадаад үйл ажиллагаанд, түүндипломат үйл ажиллагаа гэж байхаас биш Ерөнхийлөгчийн, олон улсын нэр хүндэд шийдвэрлэх хүчин зүйл болдог номтой гэж Ерөнхий Сайдын, Их Хурлын даргын гадаад бодлого гэж байх санааг улсынхаа өнөөгийн бодит байдалтай уялдуулан тунгааёсгүй. Манай эрхтэн дархтанууд гадаадад очоод огт өөр өөр үзвээс сэтгэл хангалуун байхын аргагүй боллоо. Үндэсн санаатай зүйл ярих юм гэж гайхашран буй шавийн маань үг нэгийг үйлдвэрлэлээ унагаачихсан, банк санхүүгийн хямралд автсч бодогдуулна. Олон улсын түвшинд ч, хоёр талын харилцааны хөдөө аж ахуй, хүнсний зах зээлийн санаачилгаа алдсасуудлуудад ч залгамж чанар гэдгийг анхаарах учиртай. Японы ажилгүйдэл, ядуурал, өлсгөлөн нэмэгдсэн. Авиалтал, хээл хахууль эрдэмтэн Монголын Сайд, дарга нарын тухай Монголын нэгэн архидалт газар авч улсын хөгжих замд садаа болж буйг хэн хүн академичид: Танай сайд дарга нар манай улсад очоод өөрийн л мэдэж байгаа. Гэтэл зарим "улс төрч" амьдрал сайхан байн бизнес, хүүхдийнхээ сургууль соёлын талаар л ярих юм. Улсын Гудамжаа харцгаа, гадаадын олон янзын машин сүлжилд ажил, хариуцлага гэж байдаг биз дээ гэж мушилзаж байсан гэнэ байгааг, хотын дотор ТУЦ олширсныг гэж буйг нь чихээрээ сонсо. Аль ч улсын төрийн түшээ хүний үг албан ёсны, хариуцлагатай юм. Монгол орны хөгжил дэвшил, хүн ардын амьдралын түвшин байх учиртай. Төрийн тогоонд чанагдаж баймааж амьдралаас гадаадаас оруулж ирсэн хуучин нь голдуу машинаар, эсвэл Түрслэлцэн хатууждаг юм даа. Ушигтай бүхэн Английн парламент үйлчилгээний Цэгийн тоогоор хэмжмээрүй л юм даа.

Гадаад үнд ажиллагаа нэгдмэл байх нь чухал.

Сүүлийн жилүүдэд манай төр, засгийн дээд тушаалтнууд гадаад харилцаа холбоо ихээхэн тэллээ. Энэ ч аргагүй. Гэхдээ Хурлын гишүүд, төрийн гурван томоохон эрхтэн хаана явж, ямарх зардал гаргасныг тооцвол нилээд олон зуун саяын тоо гарна. Алч соёлтой улсын гадаад бодлого нэгдмэл, залгамж чанартай басхуламжигдалдаа тулгуурласан байдаг юм. Гадаадад ямар зорилготой яваад, юу ярьж, юу шийдвэрлэдэг хүмүүс вэ? Томчуудыг давхардсан олон айлчлал улс орны маань хөгжил, хүн ардыг амьдрал ахуйд ямар жинтэй хувь нэмэр оруулав гэдэг нэн сонин. Зөвхөн 1999 оны эцэс, 2000 оны эхээр манай Ерөнхийлөгч Солонгос, Хятад, Япон зэрэг орноор айлчлаад ирсний дараахаараас нь Ерөнхий Сайд нь, хэдхэн сарын дараа Их Хурлын Дарухалун мөрөөр нь мөнөөхөн улсуудад айлчлаад ирж байна билээ. Тэд бүгд гэргийгээсээ авахуулаад олон түшмэл, хиа дагуулан суудуулиантай мордоцгоосон. Тэдний аль нэг нь, ядахдаа хоёр нь улсаа төлөөлсөн ажил хэрэгч айлчлал хийгээд ирэх боломжтоймэт санагдана. Албаа ашиглаад улс орон үзвэ, авга

түүхдүүдийнхээ нүдийг нээе гэсэн бодол хүнд байдаг л байх л даа. Мэргэжлийн үүднээс үзвэл Монгол улсын гадаад бодлого, дипломат үйл ажиллагаа гэж байхаас биш Ерөнхийлөгчийн, Ерөнхий Сайдын, Их Хурлын даргын гадаад бодлого гэж байх эрсгүй. Манай эрхтэн дархтанууд гадаадад очоод огт өөр өөр санаатай зүйл ярих юм гэж гайхашран буй шавийн маань үг нэгийг бодогдуулна. Олон улсын түвшинд ч, хоёр талын харилцааны асуудлуудад ч залгамж чанар гэдгийг анхаарах учиртай. Японы эрдэмтэн Монголын Сайд, дарга нарын тухай Монголын нэгэн академичид: Танай сайд дарга нар манай улсад очоод өөрийн бизнес, хүүхдийнхээ сургууль соёлын талаар л ярих юм. Улсын ажигл, хариуцлага гэж байдаг биз дээ гэж мушгилаж байсан гэнэ. Аль ч улсын төрийн түшээ хүний үг албан ёсны, хариуцлагатай байх учиртай. Төрийн тогоонд чанагдаж баймааж амьдралаас агууралцан хатууждаг юм даа. Ушигч та бүхэн Английн парламент, АНУ-ын Конгресс, Бүх Хятадын Ардын Хурлын Чуулганы гишүүдийн нас суудар, намба төрхийг ажиглаарай. 1996 онд сонгогдсон Их Хуралд „тохиолдлын чанартай багачууд их орлоо.“ Ганзаглын наймаачдын гадаад бодлого” явж байна гэх маягийн шүүмжлэл гарч л байлаа.

Тэгсэн атлаа „Жасрай өвөө” гэж дуооголсон шар хэвлэлийн нийтлэл гарч байв. <<Амны нь салга ариглаагүй>> банд нарт Тэр өвөөгөөс авах сурах юм ч олон л бий дээ. „Жоу Энх Лай өвөө”, „Ден Сю Пин өвөө”, „Цериль өвөө”, Де Голль ер нь нэртэй хүмүүс. Тэд гол нь халуун эх орончид байсан.

1997 оны нэг өдөр Бээжингээс Токיו руу манай Их Хурлын 5-6 гишүүн нисч, арваад хүн Америкаас ирж байна гэв. Бас Их Хурлын эрхэм гишүүн, Сайд нийлсэн 10 гаруй хүн хамтдаа эхнэр хүүхдээ дагуулан АНУ-ын нэг муж улсад очоод уулзалт хийгээд буцаж байгааг нүдээрээ харсан. Тэдний хамт хотын дарга, томоохон пүүсийн захирал 4-5 хүн явж байж билээ. Гадаадын төслийн хөрөнгөөр гадаад явж буй 4-5 хүний хамт Их Хурлын эрхэм гишүүн, Е-серийн гадаад улаан паспорттой хувийн пүүсийнхэнийг дагаад явж байна гэнэ. Тэд ардаа ажилтай л баймаарсан. Ар талд нь мал нь тэжээлгүй, зуд турханд малчид нь зутарсан, нийслэл хот нь хогондоо дарагдсан гээд эрхэм түшээдийн санаа зовмоор зүйл мөн ч олон байна даа. Бас Их Хурлын ирц нь бүрддэггүй.

паспорттай хүн ч байдаг суралтай юм билээ. „Ардчилалын буянааг ингэж тогтоцгоов. Улсын нэр хүндэд халтай тэдний ийм бизнесийг гэм буруутган гэм зэмгүй л өнгөрч байлаа. Сүүлийн жилүүдэд радиотелевизээр Солонгосын виз, Америкийн, Германы „виз түргэ гаргана“ гээд, түүнд нь хууртсан хичнээн ч хүн хохирч байна. Засаг төр нь ч, иргэд нь ч, ерөөсөө хашраахгүй, тоохгүй явж иржээ.

Мөхөс би гадаад харилцаа, гадаад бодлогын салбарт гарсаа олон ололт амжилтыг бүхэлд нь үгүйсгэх гэсэн юм биш ээ. Зөвхөн засуулштай бөгөөд улс орны аюулгүй байдал, нэр хүндэд хортой зарим нэг үйлдэл, бодчиггүй хэрэг явдлын талаар судлаачийн хувьд уншигч олонтойгоо саналаа хуваалцаж буй нь энэ юм. Үүнтэй холбогдуулан гадаад харилцаа намчирхах, нутгархах явдал, элдэв бүлгийн ашиг сонирхлоос ангид байх ёстой үздэгээ дурьдъя. Нэг сургуулийн орос хэлний багш Гадаад Хэргийн сайд, нэг намын дарга Элчин сайд, ганзагын наймаачид дипломат болж байх юм <<Дипломат, гадаад харилцаа мэргэжил биш>>, хэн дуртай нь хийдэг улс төр гэж үзэж туйлширч болохгүй гэж үзнэ.

Дэлхийн олон орны эрдэмтэд, судлаачид гадаад бодлого дипломат ажиллагааг шинжлэх ухаан хэмээн хүлээн зөвшөөрч, онол үзэл баримтлал боловсруулж мөрдөж ирсэн байна. Олон улсын харилцааны түүх, эрх зүй, улс төр судлал, эдийн засгийн харилцааны салбаруудын эрдэмтэдийн бүтээл туурвилыг тоолоод баршгүй. Бид Англи, АНУ, Франц, Орос, Герман, Япон зэрэг улсын судлаачдаас тоймтой нэрд гарсан бүтээлүүдээс нь суралцах судалж байна. Тэхээр ОУХ, дипломат ажиллагаа мэргэжил, тэхдээ бүр нарийн бөгөөд онол, практикийн хослолд тулгуурласан баймааж үр өгөөжтэй байх мэргэжил мөн.

Эл байдлаас үүдэн Улсын Их Хурал, „Дипломат албаныхууль“ гаргасныг судлаачийн хувьд бүрэн дэмжсэн юм. Гадаад Хэргийн Яам, төр улсын гадаад үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах түүнд хяналт тавих болж буй нь зүйтэй. Харин дээдэс маань хууль дээдэлж түүнийг биелүүлэх ёстой. Турга тусгаар Монгол улсын хөгжил, цаашилбал хувь заяанд гадаад ая таатай нөхцлийг бүрэлдүүлэхэд энэ хууль чухал хувь нэмэр болно хэмээн итгэж явна.

Монгол улсын гадаад харилцааг нэгдмэл, нэгэн зорилготой чиглүүлэн, өнгөрсөн үеэсээ сургамж авсан, олон улсын

харилцааны өнөөгийн хандлага, өнө хэтээ <<даяарчлалын>> энэ катуухан орчинд зохицсон уян хатан прагматик арга ухаанаар хэллэн явуулах нь чухал юм. Тэрхүү <<даяарчлалын>> орчинд Монголын зах зээл, бүтээгдэхүүний талаар өрсөлдөх чадвар бүрэлдэж байна уу? Бидний ярих дуртай болсон монгол хүний аюулгүй байдал, сайн засаглал хангагдаж хэрэгжиж байна уу?

Гадаадын зээл тусламжийг үр өгөөжтэй ашиглаж чадав уу? гэж нэгэн өдөр төрөөс асууна!

Гадаад бодлого, дипломат ажиллагаа бүхэлдээ Монголын дотоод амьдралыг тохиуруулахад чиглэсэн, үндэсний эрх ашгийг дээдэлсэн, эх оронч нэгэн үзүүрт сэтгэл өвөртөлсөн баймааж нь турга тусгаар улс маань 21-р зуунд улс үндэстнээ дэлхийн олон үндэстний тоосонд даруулахгүй тэсэж үлдэж <<Монгол гэдэг эрийг ертөнцийн чихнээ>> дуурсгаж явах болно.

ГЕОПОЛИТИК БА УЛСЫН ХҮЧ ЧАДАА, БОДЛОГО

МУИС, ОУХС-ийн багш,
Онц бөгөөд бүрэн Эрхт
Элчин Х.Олзвой

Геополитик (газарзүйд үндэслэсэн бодлого) бол газарзүй, улсын чадал боломж болон олон улсын бодлого дээр төвлөрсөн ухаан, үйл ажиллагаа юм. 1800-аад оны сүүлээр анх үндэслэгдсэн геополитикийн онол нь 20-р зууны эхээр ихээхэн газар авч байснаа дэлхийн хоёрдугаар дайны үеэр нацист Герман түүнийг амьдрах орон зайгаа („lebensraum“) тэлэх эрмэлзлээ зөвтгөх онолын үндэслэл болгосноос дэлгэрэлт нь зогсонги болж харгис үзлийн хэлбэр хэмээн шүүмжлэгдсэн билээ. Эхний үеийн болон ид цацгэлалтийн үеийн олонхи геополитикч улс бол „амьд биет“ учраас тэлж өргөжиж байх ёстой агаад эс тэгвээс нөхөх, төлжих, хөгжих нөхцөлгүй болно гэсэн шугамыг барьж байлаа. Далайд ноёрхох, мөн колони эзэмшлийн нутагтай болох нь дэлхийд нөлөө, хүчээрээ ноёрхох үндэс гэсэн Альфред Махэн, Европ, Ази, Африк нь „дэлхийн арал“ бөгөөд түүний төв болсон Евроазийн „зүрхэн газар“ („Heartland“) -т нөлөө хүчээ тогтоовол дэлхийг захирна гэсэн Х.Маккиндер, Европ, Ойрхи Дорнод, Африк, Өмнөд Америк, Азийн